

ДАРГА БАТЛАВ БОЛОРЖАРГАЛ

2022 оны 04 сарын 20

9033211 © ГТА0485  
0622010012

САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНД  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр үйлдэв.

Сайхан-Овоо сум

Д/д	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
1	Байгууллагын дотоод журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхэд тавих хяналт, шалгалт	1-р улирал	Ажлын хэсэг	Албан хаагчдын ажлын хариуцлага дээшилж, ажлын бүтээмж нэмэгдсэн байх
2	Ажлын цаг ашиглалтад тавих хяналт, шалгалт	1-р улирал	Ажлын хэсэг	Ажилчдын ажлын үүрэг, хариуцлага, ажлын цаг ашиглалт сайжирна.
3	Хууль тогтоомж холбогдох эрх зүйн актуудыг иргэд олон нийтэд мэдээллэх, сурталчлан таниулах ажлын хэрэгжилтэд хяналт тавих	1, 2, 3, 4-р улирал	Ажлын хэсэг	Төрийн үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод нээлттэй, түргэн шуурхай хүргэх хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.
4	Байгууллагын мөрдөж ажиллах, хэрэгжүүлэх хууль тогтоомж журам, эрх зүйн актуудын биелэлт, үр дүнгийн байдлын холбогдох стандартын хэрэгжилтэд хяналт тавих	2, 4-р улирал	Ажлын хэсэг	Хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирч, зөрчил дутагдалгүй ажиллана.
5	Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдох стандартын хэрэгжилтэд хяналт тавих	2, 4-р улирал	Ажлын хэсэг	Эрүүл аюулгүй ажлын орчин бүрдэнэ.
6	Байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийн байдалд судалгаа шинжилгээ явуулж сайжруулан зөвлөмж хүргүүлнэ.	1, 3-р улирал	Ажлын хэсэг	Төрийн үйлчилгээ иргэдэд ил тод шуурхай чанартай хүрч ажлын бүтээмж дээшилнэ.

7	Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл байгаа эсэхэд хяналт шалгалт хийх	2-р улирал	Ажлын хэсэг	Байгальд ээлтэй үйл ажиллагаа бий болж хандлага сэтгэлгээ тогтон ажиллаж амьдрах нөхцөл бүрдэнэ.
8	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдалд үнэлэлт өгөх	1, 2, 3, 4-р улирал	Ажлын хэсэг	Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангасан байна.
9	Байгууллагын өмчийн бүртгэл тооцоо ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт, шалгалт	2, 4-р улирал	Ажлын хэсэг	Өмч хөрөнгийн бүртгэл, хамгаалалт ашиглалт сайжирч үргүй зардал буурч, эд хариуцагчийн үүрэг дээшилнэ.
10	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлд тавих хяналт, шалгалт	2-р улирал	Ажлын хэсэг	Төсвийн хэмнэлттэй, үр ашигтай зарцуулалт сайжирна.
11	Төсвийн гүйцэтгэл болон Төсвийн ил тод байдалд тавих хяналт, шалгалт	2-р улирал	Ажлын хэсэг	Төсөв санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэл ил тод болно.
12	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих, шалгалт	4-р улирал	Ажлын хэсэг	Хоршоо хөгжүүлэх сангийн зарцуулалт, гүйцэтгэл сайжирна.
13	Хууль тогтоомжийн хэрэгжилт болон өмнө нь хяналтын байгууллагаас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих	3-р улирал	Ажлын хэсэг	Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийг аривлан хэмнэх, үйл ажиллагааны үр дүн нэмэгдэх.

## ДОТООД ХЯНАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

**САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНД  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Гүйцэтгэх ажил	Хэрэгжилт	Биелэлт хувь
1	Байгууллагын дотоод журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхэд тавих хяналт, шалгалт	2022 онд Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Байгууллагын дотоод журамд хууль нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулж, албан хаагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдгээрийн нийгмийн баталгааг хангах, хөдөлмөрийн тухай хуульд шинээр нэмэгдсэн онцлог заалтуудыг дотоод журамдаа тусгаж хуулийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Сахилгын зөрчил, ёс зүйн доголдол гаргасан албан хаагч байхгүй байна.	100%
2	Ажлын цаг ашиглалтад тавих хяналт, шалгалт	Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг нүүр царай таних цаг бүртгэдэг машиныг ашиглан бүртгэж ажлын цагийг тооцон ажиллаж байна. Мөн цахим шилжилттэй холбоотойгоор егр системд цаг ашиглалтыг программ суулгаж, Байгууллагын дарга цаг ашиглалтыг тухай бүр хянаж, тайлан гаргах бүрэн боломжтой болсон байна.	100%
3	Хууль тогтоомж холбогдох эрх зүйн актуудыг иргэд олон нийтэд мэдээллэх, сурталчлан таниулах ажлын хэрэгжилтэд хяналт тавих	Хүчингүй болсон болон шинэчлэн найруулсан хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, тэдгээртэй холбогдон гарч буй тогтоол, захирамж, тушаал, бусад эрх зүйн актуудыг тухай бүр албан хаагчид болон иргэд, олон нийтэд мэдээлж, танхим болон цахим байдлаар сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж байна.	100%
4	Байгууллагын мөрдөж ажиллах, хэрэгжүүлэх хууль тогтоомж журам, эрх зүйн актуудын биелэлт, үр дүнгийн байдлын холбогдох стандартын хэрэгжилтэд хяналт тавих	Эрх зүйн зөрчилгүй акт, тушаал шийдвэр гаргах, зөрчлийг арилгах, дээд байгууллагын зөвлөмж, шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлэхэд дотоод хяналт тавин ажиллаж байна	100%
5	Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдох стандартын хэрэгжилтэд хяналт тавих	Сумын Засаг даргын 2021 оны 04 сарын 05-ны өдрийн А/48 дугаар захирамжаар томилогдсон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг	100%

		<p>зөвлөлтэй хамтран төсвийн байгууллага тус бүр дээр ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийж, зөвлөгөө мэдээллээр хангаж, "Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлбэ" сарын аяныг амжилттай зохион байгуулсан. Мөн дотоод хяналтын ажлын хэсэг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтад цахимаар хамрагдан албан хаагчдыг мэдээ мэдээллээр хангаж, холбогдох стандартын хэрэгжилтэд байнгын хяналт тавин ажиллаж байна.</p>	
6	<p>Байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийн байдалд судалгаа шинжилгээ явуулж сайжруулан зөвлөмж хүргүүлнэ.</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах тал дээр албан хаагчдаас судалгаа авч, ажлын хариуцлагыг сайжруулах, баримт бичгийн эмх цэгцгийг хангах сэдвүүдээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүний үр дүнд албан хаагчид зөв хандлагыг ажлын байран дээр болон иргэд үйлчлүүлэгчдэд түгээж, хүнд суртал, чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчлэх боломжийг ханган ажиллаж байна. Иргэдэд онлайнаар болон цахимаар мэдээллээ, төрийн үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Дотоод хяналтын баг сургалт сурталчилгааг тогтмол явуулж, судалгаа шинжилгээ явуулан ажиллаж байна.</p>	100%
7	<p>Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл байгаа эсэхэд хяналт шалгалт хийх</p>	<p>Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Сумын төвөө ногооруулах, хогоо ангиалан ялгах, хогийн цэгийг цэгцлэх, мод тарих, цэцэрлэг хүрээлэнтэй болох гэх мэт олон байгальд ээлтэй ажлуудыг зохион байгуулж түүнд хяналт тавин ажиллаж байна.</p>	100%
8	<p>Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдалд үнэлэлт өгөх</p>	<p>Дундговь аймгийн сайтад мэдээллийн ил тод байдлын шалгуурын дагуу мэдээллээ оруулж буй эсэхэд болон байгууллагын ил тодын самбаруудад мэдээллээ тавьж буй эсэхэд байнгын хяналт тавьж үнэлгээ дүгнэлт өгөн ажиллаж байна. Цахим сайтад оруулсан мэдээллийн дундаж 56%, сумын Пэйж хаяг болон байгууллагын ил тод, үйл</p>	100%

		ажиллагааны самбаруудад тавьсан, шинэчлсэн мэдээллийн дундаж 95% байна.	
9	Байгууллагын өмчийн бүртгэл тооцоо ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт, шалгалт	Байгууллагын хагас жилийн болон жилийн эцсийн тооллогыг даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг тухай бүр нь нүдээр үзэн тоолж, өмчийн бүртгэл тооцоо, хадгалалт, ашиглалтад хяналт тавин ажиллаж чанарын шаардлага хангахгүй, элэгдсэн, муудсан, актлах, устгах эд хөрөнгийг журмын дагуу актлах ажлыг зохион байгуулсан ажлын хэсэгт хяналт тавин ажиллаж байна.	100%
10	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлд тавих хяналт, шалгалт	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлд байнгын хяналт тавьж, шаардлагатай зөвлөгөө мэдээлэл, удирдлага зүйгээр ханган ажиллаж байна.	100%
11	Төсвийн гүйцэтгэл болон Төсвийн ил тод байдалд тавих хяналт, шалгалт	Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэл, хэмнэлтэд хяналт тавих, төсвийн ил тод байдлыг нийтэд мэдээлж дотоод хяналтын ажлын хэсэг тогтмол хяналт шалгалтаа хийж байна.	100%
12	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих, шалгалт	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавин ажиллаж байна.	100%
13	Хууль тогтоомжийн хэрэгжилт болон өмнө нь хяналтын байгууллагаас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих	Хяналтын байгууллагаас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах ажлыг тогтмол явуулж байна.	100%

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН: АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,  
 Р.ТУНГАДАГТУЯА  
 САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА

ХЭРЭГЖИЛТ ХЯНАСАН: ЗДТГ-ын ДАРГА  **Б.БОЛОРЖАРГАЛ**

